



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 12 өдөр

Дугаар А/101

Мөрөн сум

Газар эзэмших эрхийн гэрчилгээний
хугацаа сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, 37 дугаар зүйлийн 37.1, 37.2, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, Газрын харилцаа, геодези зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Газар эзэмшигч иргэн Барга овгийн Пунцагийн Сэлэнгэ (РД77022818)-ийн Мөрөн сум 3 дугаар баг 1-216 тоотод байршилтай 6712014284 нэгж талбарын дугаартай 799м² худалдаа, нийтийн үйлчилгээний газрын зориулалтаар эзэмшүүлсэн газрын газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацаа дууссан тул өөрийнх нь хүсэлтийн дагуу 20 жилийн хугацаагаар сунгаж эзэмшүүлсүгэй.

2. Уг захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2022 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн А/182 дугаар захирамжийн хавсралтын 5 дахь заалтыг хүчингүй болгосугай.

3. Захирамжаар газар эзэмшигч иргэн П.Сэлэнгэтэй газар эзэмших эрх зүйн баталгаажилт хийж, Улсын бүртгэлд бүртгэхийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Ганзориг)-т, Улсын бүртгэлийн хэлтэс (Б.Мөнгөнзул)-т нарт тус тус зөвшөөрсүгэй.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс дарга (Р.Машбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ